



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/40

Хархорин сум

Эзэмшил газрын зориулалт  
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Соёмбо хороолол 58 тоотод Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 6209007937 нэгж талбарын дугаартай 1381 м2 газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу Үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2.Газар эзэмшигч Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Э.Дэнсмаа), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100079